

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	11
4.2. Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	13
4.3. Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.4. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	15
4.5. Аудит хийсэн Зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлан	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НББ	Нягтлан бодох бүртгэл
ААН	Аж ахуй нэгж
УТЗ	Урьдчилж төлсөн зардал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.УДААНЖАРГАЛ ТАНАА

2020.03.16 № 06/885
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Тавантолгой төмөр зам” ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар, Татварын бүртгэлтэй холбоотой асуудлын талаар зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайланг хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс 3 дугаар сарын 10-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Конфиденсе Аудит” ХХК-ийн П.Ариунаа ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 5/100 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрхэм зорилго:

- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн засаглалын бие даасан, хараат бус байдлыг дээшлүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Компанийн санхүү, эдийн засгийн нөөц боломжийг бүрдүүлэх, баталгаажуулах;
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг хийж гүйцэтгэх;
- Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах;
- Төмөр замын тээвэрлэлт хийх.

Үйл ажиллагааны чиглэл:

Хувьцаат компанийн дүрмээр “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төмөр замын суурь бүтэц барих;
- Төмөр замын суурь бүтэц ашиглах;
- Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн засварлах;
- Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийг Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 8-ны 242 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 2 дугаар тогтоолын хавсралтаар компанийн шинэчилсэн дүрмийг баталсан. Шинэчилсэн дүрмээр нийт хувьцааны 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК тус тус эзэмшихээр заасан байна.

“Тавантолгой төмөр зам” ХХК үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах шатандаа ажиллаж байна.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ “Прософт систем” ХХК-ийн “Прософт” санхүүгийн программ хангамжийг ашигладаг байна.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 чиглэлд 13 нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 2 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь:

- 2019 онд толгой компаниас санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба жилийн эцсээр нийт санхүүжилтийн 90 орчим хувийг гэрээт байгууллагад шилжүүлж УТЗ-аар бүртгэсэн. Үүнээс шалтгаалан материаллаг байдлыг балансын дүнгээс тооцолгүй орлогод суурилж тооцоолсон.
- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны борлуулалт 3,993.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 79.9 сая төгрөгөөр төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан бөгөөд гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг хэвээр үлдээв.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 309,999.2 сая төгрөгөөр өссөн. Материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж төлсөн тооцоо, эздийн өмчийн бусад хэсэг данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.1	20,341.6	20,340.5
Авлага	-	541.6	541.6
Урьдчилж төлсөн тооцоо	12.5	286,526.9	286,514.4
Бараа материал	0.2	923.2	923.0
Үндсэн хөрөнгө	-	1,679.8	1,679.8
Нийт хөрөнгө	13.8	310,013.1	309,999.4
Богино хугацаат өр төлбөр	12.8	304.1	291.4
Өмч	1.0	1.0	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	308,872.7	308,872.7
Хуримтлагдсан ашиг	-	835.3	835.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	13.8	310,013.1	309,999.4

Урьдчилж төлсөн тооцоо данс өссөн нь төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой урьдчилж төлсөн төлбөрүүдээс шалтгаалжээ.

Эздийн өмчийн бусад хэсэг данс өссөн нь толгой компаниас олгосон хөрөнгө оруулалтаас шалтгаалсан байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 03 дүгээр тогтоолоор “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлж явуулахад шаардлагатай зарим зардлыг эхний ээлжинд санхүүжүүлэх зорилгоор 2019 оны зардлыг 2,585.7 сая төгрөгөөр баталсан.

Цалин нийгмийн даатгалын зардал хэтэрсэн нь 11,12-р сард "Монголын төмөр зам" ТӨХК нэмэлт гэрээний дагуу орон тоо нэмэгдсэнтэй холбоотой нэмэлт цалин гарсан байна. Бусад холбогдох зардал хэтэрсэн нь хөлсөөр ажиллах гэрээтэй ажилчид нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 26,065.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 26,059.0 сая төгрөгийн алдааг залруулж, 6.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Залруулгын талаарх тодруулга:

- ААНОАТ-ын өглөгийг үүсгэж 7.0 сая төгрөгөөр залруулав

- Хүүгийн орлогыг татвар хассан цэвэр дүнгээр тайлагнасан байсныг 85.8 сая төгрөгөөр залруулав
- Гүйцэтгэгчид төлсөн төлбөрөөс хэрэгжээгүй НӨАТ-ын авлагыг салгаж 26,047.9 сая төгрөгөөр залруулав
- Хэрэгжээгүй НӨАТ-ын авлагыг дансны бүлэг хооронд 4.0 сая төгрөгөөр залруулав
- Мөнгөн гүйлгээний тайлангын үзүүлэлт хооронд 286,975.6 сая төгрөгөөр залруулав

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Урьдчилж төлсөн зардал дансны бүртгэл үнэн зөв явж байгаа эсэхийг анхаарах, Эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн болон өмчийн бүртгэлийг зөв оновчтой бүртгэж тайлагнах, дүрэм болон улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулсан эсэхийг анхаарах.

Тус компанийн үйл ажиллагаанд нь толгой болон бусад хөрөнгө оруулагч компаниудтай уялдуулан гүйцэтгэлийн аудит оруулах санал оруулж байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Тавантолгой төмөр зам” ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3-т “төрийн нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал энэ хуульд хамаарахгүй” гэж заасны дагуу www.shilendans.gov.mn сайтад мэдээлэл байршуулаагүй байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

2018 онд байгуулагдаж үйл ажиллагаа явуулсан боловч аудит хийгдээгүй.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Тавантолгой төмөр зам” ХХК нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

3.1.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулахаар зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч эцэслэж батлаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т *“АН байгууллагын удирдлага нь НББ-ийн хууль тогтоомж стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн НББ-ийн баримт бичгийг баталж мөрдөж ажиллана”* гэснийг мөрдөөгүй.

3.1.2. Эрсдэл:

Бодлого тууштай хэрэгжихгүйгээс санхүүгийн тайланг тайлант үеүдийн хооронд зэрэгцүүлэх боломжгүй болно.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

НББ-ийн бодлогын баримт бичгийн урьдчилсан байдлаар ирүүлсэн хувилбарыг сайтар уншиж үйл ажиллагаандаа чиглэсэн, нарийн заавар журам, тооцооллыг оруулж авах хэрэгтэй. Мөн толгой компани болох “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн бүртгэлийн бодлогыг PWC олон улсын компани бичиж байгаа энэ үед зөвлөгөө авч ажиллах боломж байгаа гэдгийг сануулж байна. Нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг учраас толгой компанийн бодлогыг хэрхэн ашиглах, яаж нийцүүлэх тухай тусгайлсан зөвлөгөө авч бодлогодоо тусгуулах хэрэгтэй.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Татварын бүртгэлтэй холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангаар хөрөнгийг худалдан авсан өдрөөс эхлэн элэгдүүлдэг, татварын хуулиар худалдан авсан өдрийн дараа сараас эхлэн элэгдүүлэхийг зөвшөөрдөг. Үүнээс шалтгаалан татварын зөрүү 6.0 сая төгрөгөөр үүссэн боловч зөрүүгийн тайлан бэлтгээгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Тайлант үеийн зөрүү бага боловч цаашид ихээр үүсэх, татварын тайлан алдаатай илэрхийлэгдэх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авсан хөрөнгийн хувьд элэгдүүлж эхлэх хугацааг татварын хуультай ижил болгоод бусад хэлбэрээр үүссэн зөрүүг татварын зөрүүгийн тайлангаар шийдвэрлэж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 6 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

“Тавантолгой төмөр зам” ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3-т “төрийн нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал энэ хуульд хамаарахгүй” гэж заасны дагуу www.shilendans.gov.mn сайтад мэдээлэл байршуулаагүй байна.

3.3.2. Эрсдэл:

Шилэн дансны хуулийг мөрдөхгүй байх эрсдэлтэй.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Нууцад хамаарахаас бусад мэдээллүүдийг шилэн дансны хуулийн дагуу байршуулах шаардлагатай.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 -р сарын 31	2019 оны 12 -р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,053,795.00	20,341,567,727.10
1.1.2	Дансны авлага	-	385,250.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	26,589,139,725.06
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	160,500.00	923,259,252.79
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,541,419.28	260,478,973,276.43
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,755,714.28	308,333,325,231.38
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	1,653,933,898.79
1.2.2	Биет бус хөрөнгө	-	25,904,071.81
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	1,679,837,970.60
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,755,714.28	310,013,163,201.98
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,600,000.00	35,606,542.12
2.1.1.2	Цалингийн өглөг	7,905,023.14	-
2.1.1.3	Татварын өр	804,262.57	217,930,265.63
2.1.1.4	НДШ–ийн өглөг	2,446,428.57	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	50,600,000.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,755,714.28	304,136,807.75
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	12,755,714.28	304,136,807.75
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.2	- хувийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	308,872,700,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	835,326,394.23
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,000,000.00	309,709,026,394.23
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,755,714.28	310,013,163,201.98

4.2. Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 -р сарын 31	2019 оны 12 -р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	3,132,330,888.18
2	Борлуулалтын өртөг	-	3,064,979,581.59
3	Нийт ашиг(алдагдал)	-	67,351,306.59
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	858,022,180.69
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	2,847,500.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	-
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	928,220,987.28
19	Орлогын татварын зардал	-	92,894,593.06
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	835,326,394.22
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	835,326,394.22
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3. Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	-	-	1,000,000.00
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
11	Залруулсан үлдэгдэл				
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			835,326,394.22	835,326,394.22
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт		308,872,700,000.00		
15	Зарласан ногдол ашиг				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
17	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	308,872,700,000.00	835,326,394.22	309,709,026,394.22

4.4. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12 -р сарын 31	2019 оны 12 -р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	2,740,410,049.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	2,736,059,196.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	2,618,353.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	1,732,500.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	(3,278,621,113.64)
1.2.1	Ажиллагчдад төлсөн	(1,546,205.00)	(1,609,623,661.17)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	(423,929,397.11)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	(430,753,587.38)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(160,500.00)	(41,190,632.85)
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	(440,800,221.13)
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	(279,005.00)	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	(71,205,725.69)
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	(261,117,888.31)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,106,700.00)	(538,211,064.64)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	862,382,134.69
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	4,359,954.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	858,022,180.69
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8		-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	(288,853,400,337.95)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	(1,881,100,910.00)
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	(26,134,602.88)
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	(286,946,164,825.07)

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6			-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(287,991,018,203.26)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,600,000.00	308,979,705,558.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	107,005,558.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	308,872,700,000.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4		1,600,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	(109,962,358.00)
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	(109,962,358.00)
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5		-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,600,000.00	308,869,743,200.00
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	53,795.00	20,340,513,932.10
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,000,000.00	1,053,795.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,053,795.00	20,341,567,727.10

4.5. Аудит хийсэн Зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүн	Хувь
1	Үндсэн цалин	1,210,829,271.91	1,448,744,000.00	237,914,728.09	120%
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,279,000.00	248,806,099.41	125,527,099.41	202%
3	Бичиг хэрэг, бараа, үйлчилгээний бусад зардал	273,833,900.00	221,810,510.00	(52,023,390.00)	81%
4	Байр ашиглалттай холбоотой зардал	86,950,000.00	47,018,850.00	(39,931,150.00)	54%
5	Авто машин ашиглалтын зардал	121,538,320.00	96,669,000.00	(24,869,320.00)	80%
6	Гадаад, дотоод албан томилолт	72,400,000.00	55,309,548.00	(17,090,452.00)	76%
7	Хурал зөвлөлгөөн, сургалт семинар, судалгааны ажлын зардал	60,600,000.00	61,994,370.00	1,394,370.00	102%
8	Бусад холбогдох зардал	636,283,350.00	884,627,116.00	248,343,766.00	139%
	Нийт дүн	2,585,713,841.91	3,064,979,493.41	479,265,651.50	8.54

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2019/116/14-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын	“Тавантолгой төмөр зам” ХХК		сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг бичүүлэхээр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч эцэслэж батлаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Т.Найдан
2	Санхүүгийн тайлангаар хөрөнгийг худалдан авсан өдрөөс эхлэн элэгдүүлдэг, татварын хуулиар худалдан авсан өдрийн дараа сараас эхлэн элэгдүүлэхийг зөвшөөрдөг. Үүнээс шалтгаалан татварын зөрүү 6,035.0 мянган төгрөгөөр үүссэн боловч зөрүүгийн тайлан бэлтгээгүй байна.	6.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Т.Найдан
3	“Тавантолгой төмөр зам” ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3-т “төрийн нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал энэ хуульд хамаарахгүй” гэж заасны дагуу www.shilendans.gov.mn сайтад мэдээлэл байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Т.Найдан
Дүн		6.0			

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 28 lines spaced evenly down the page.